



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 09 өдөр

Дугаар А/174

Чингис хот

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.20 Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус аймгийн Хэрлэн, Бор-Өндөр сумдад Коронавирусын цар тахлын тохиолдол батлагдсантай холбогдуулан батлагдсан тохиолдлын ойрын болон дам хавьтлыг түргэн шуурхай илрүүлэх, тархалтыг таслан зогсоох зорилгоор Политехникийн коллежид гамшгаас хамгаалах шуурхай штаб, хариу арга хэмжээний багийг вакуумжуулан ажиллахад шаардлагатай хоол хүнс, бичиг хэргийн материалын зардалд хөрөнгө зарцуулсугай.

2. Хөрөнгө зарцуулах тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх зардалд шаардагдах 965,366 (есөн зуун жаран таван мянга гурван зуун жаран зургаа) төгрөгийг аймгийн Гамшгийн эрсдэлийг бууруулах сангаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д зөвшөөрсүгэй.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ц.Чогсомжав)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231011520

Аймгийн Засаг даргын 2021 оны
04 дугаар сарын 09 өдрийн
дугаар захирамжийн хавсралт



Хөрөнгө зарцуулалтын тооцоо

№	Байгууллагын нэр	Зардлын нэр төрөл		Дүн
		Хоол хүнс	Бичиг хэрэг	
1	Онцгой байдлын газар	313,566	651,800	965,366
Нийт		313,566	651,800	965,366